

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021оны 08 дугаар сарын 12-ны өдөр  
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112452

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Өндөрцагаан-1 (MV-011721) талбайд хийгдэх геофизикийн соронзон хайгуул хийх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших MV-011721 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай геофизикийн соронзон хайгуул хийх зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хэтийн төлөв тогтоох, үнэлэх, цаашид тухайн талбайд гүйцэтгэх ГХА-ыг хэрхэн гүйцэтгэх талаар зөвлөмж гаргах болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
  - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн тайлан ирүүлэх/,
  - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
  - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 08 дугаар сарын 18–ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 10 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 10.10 цагт цахимаар нээнэ.

### **“Монголросцветмет” ТӨҮГ**

**Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002**

**Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.**

**22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,**

**И-мейл: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn).**

**Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158**